

## META VERIFIED

*Meta Verified* нь Инстаграм болон Фэйсбүүк дээрх баталгаажсан тэмдгийг авах боломжийг хүн бүхэнд олгож буй **төлбөрт үйлчилгээ** юм. Тус үйлчилгээ нь таван төрлийн сонголт бүхий багцтай (*Meta Verified Standard* - \$14.99/month, *Meta Verified Business Standard* - \$14.99/month, *Meta Verified Business Plus* - \$44.99/month, *Meta Verified Business Premium* - \$119.99/month, *Meta Verified Business Max* - \$349.99/month).

*Meta Verified*-ийн хүсэлт гаргахад дараах **шаардлага** тавигддаг. Үүнд:

- Хувийн эзэмшлийн бүртгэл байх;
- 18-аас дээш настай байх;
- Инстаграм ашиглах нөхцөл (*Terms of Use*), Олон нийтийн удирдамж (*Community Guidelines*), Фэйсбүүкийн үйлчилгээний нөхцөл (*Terms of Services*), Олон нийтийн стандарт (*Community Standards*)-ыг дагаж мөрдөх;
- Өөрийн нэр болон зургийг ашиглах бөгөөд иргэний үнэмлэх дээрх нэр, зурагтай тохирч байх;
- 2 шатлалт баталгаажуулалт (*Two-factor authentication*)-ыг идэвхжүүлсэн байх;
- Цоо шинэ бүртгэлээс хүсэлт гаргах боломжгүй.

*Meta Verified* үйлчилгээг авснаар дараах **давуу талтай**. Үүнд:

- Баталгаажсан тэмдэг (*Verified badge*): Таны иргэний үнэмлэхийг шалгасны дараа *Meta* танд цэнхэр тэмдэг өгөх болно;
- Хуурамч хаягуудаас хамгаалах: Хандалт өндөртэй хүмүүсийг дуурайж буй хуурамч бүртгэлүүдийг хянаана;
- Агентад хандах: Танд шууд тусламж үзүүлэх бодит агентуудад хандах боломжтой;
- Нэмэлт функцүүд: Цөөн дагагчтай хэрэглэгчдийн хувьд ашигтай бөгөөд Фэйсбүүк, Инстаграмын сэтгэгдэл, хайлт, зөвлөмж гэх мэт хэсгүүдийн харагдах байдал сайжирна.

*Meta Verified*-ийн **хүсэлтийг** дараах байдлаар гаргана. Үүнд:

- Инстаграм эсвэл Фэйсбүүк дээрх *Settings* цэсний *Accounts Center* хэсэгт нэвтэрч *Meta Verified* дээр дарна.
- Төлбөрийн хэрэгслийг сонгоно.
- *Meta Verified* үйлчилгээнд бүртгүүлэх сүүлийн үе шатанд иргэний үнэмлэхийн зураг, нэмэлтээр сельфи илгээхийг шаардана.